



БАТЛАВ.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ж.БАТ-ЭРДЭНЭ

АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫГ ХАМТРАН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2018 оны 02 дүгээр
сарын 26-ны өдөр

№ 211

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам/ “цаашид яам” гэх/ төлөөлж Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гомбосүрэн, нөгөө талаас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Тээврийн газар/цаашид Тээврийн газар гэх/-ыг төлөөлж дарга Д.Отгонбаатар нар дараах нөхцөлөөр тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Автотээврийн салбарт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх, хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү гэрээний зорилго оршино.


1.2. Нийслэл хотод автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч, жуулчин тээвэрлэх үйлчилгээ, авто үйлчилгээ, аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана.

1.3. Хяналт шалгалтын ажилд Төрийн хяналт шалгалтын тухай, Автотээврийн тухай, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам, Мэргэжлийн хяналт шалгалтын стандарт, зөвлөмж, зааврыг үйл ажиллагаандаа удирдлага болгон холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллана.

1.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмыг баримтлан хяналт шалгалтыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийхээс гадна тухайн онд хийх хамтарсан хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг баталж, шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт бус шалгалтыг хоёр тал зөвшилцөн хамтран хэрэгжүүлнэ.

1.5. Улсын байцаагчдыг сургалтад хамруулах, давтан сургах ажлыг хоёр тал хамтран зохион байгуулна.

1.6. Энэхүү гэрээ нь хоёр тал тохиролцон гарын үсэг зурсан өдрөөс эхлэн тус гэрээг дүгнэн цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдэх хүртэлх хугацаанд хүчинтэй.



Хоёр. Яамны эрх, үүрэг

2.1. Улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах, цуцлахтай холбоотой асуудлыг тус яам холбогдох журамд заасны дагуу Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

2.2. Тээврийн газарт ажиллаж буй улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй болон хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан батлан гаргасан эрх зүйн акт, мэдээллээр хангана.

2.3. Хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайланг хүлээн авч, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж, зааварчлагаа өгөх, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцуулах саналыг холбогдох газарт гаргах.

2.4. Яамнаас хийх төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтад шаардлагатай бол Тээврийн газарт ажиллаж буй улсын байцаагчдыг татан оролцуулах.

Гурав. Тээврийн газрын эрх, үүрэг

3.1. Нийслэл хотод автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч, жуулчин тээвэрлэх үйлчилгээ, авто үйлчилгээ, аюултай ачаа тээвэрлэх үйл ажиллагаанд Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг улсын байцаагчаар дамжуулан байнгын хяналт тавьж, биелэлтийг хангуулж ажиллана.

3.2. Улсын байцаагчийн эрх олгуулах, сунгуулах, цуцлахтай холбоотой асуудлыг шийдвэрлүүлэхдээ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дүгээр тушаалаар батлагдсан “Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам”-д заасан баримтыг яаманд хүргүүлнэ. (шинээр улсын байцаагчийн эрх авах албан хаагчийн холбогдох баримтыг тус яамны ЗТХХ-ээр урьдчилан хянуулсан байна)

3.3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2009 оны 214 дүгээр тушаалаар баталсан “Хуулиар эрх олгогдсон байгууллагад улсын байцаагч ажиллуулах журам”-ын 1.6-д заасныг үндэслэн өөрийн байгууллагын нэр бүхий улсын байцаагчийн акт, албан шаардлага, дүгнэлтийн хэвлэмэл хуудсыг хэвлүүлж, байцаагч нарт олгоно.

3.4. Улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг, шийтгэлийн хуудасны хэрэглээнд хяналт тавьж ажиллана.

3.5. Автотээврийн хяналтын улсын байцаагч нарыг хяналт, шалгалтад ажиллуулахдаа Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 270 дугаар тушаалаар батлагдсан “Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийн загвар, эдэлгээний хугацаа, техник хэрэгсэл түүнийг хэрэглэх журам”-ын дагуу дүрэмт хувцас, техник хэрэгслээр хангасан байна.

3.6. Улсын байцаагчийн тавьсан шийтгэлийн орлогыг сар бүр Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын “хяналтын орлого”-ын дансанд төвлөрүүлнэ.



3.7. Хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн нэгдсэн тайланг тухайн жилийн 5 болон 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод, аудитын газарт ирүүлсэн байна.

Дөрөв. Бусад асуудал.

4.1. Талууд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахад хоёр тал аливаа хэлбэрээр саад учруулахгүй.

4.2. Хамтын ажиллагааны явцад хоёр байгууллагын эрх ашиг хөндөгдсөн асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.3. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг оны эхэнд гарган хамтран батлах бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

4.4. Хамтарсан үзлэг, шалгалт, нэгдсэн арга хэмжээний дүнг гарган хэлэлцэх болон хамтын ажиллагааны бусад асуудлыг тухай бүр хамтран шийдвэрлэнэ.

4.5. Гэрээг жил бүрийн 12 дугаар сарын 28-ны өдрийн дотор дүгнэнэ.

4.6. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба гэрээний нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

4.7. Тээврийн газар нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд яам гэрээг дангаар цуцална.


4.8. Гэрээ байгуулагч байгууллага татан буугдсан, гэрээний харилцааг зохицуулсан эрх зүйн орчинд өөрчлөлт орж гэрээг дуусгавар болгох нөхцөл байдал бий болсон, эсхүл талууд харилцан тохиролцсоноор гэрээ дуусгавар болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА



НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН
ДАРГА



БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ж БАТ-ЭРДЭНЭ

2018 ОНД АВТОТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН ЦИЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 02 дүгээр сарын 26 өдөр

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	Хугацаа	Хариуцсан албан тушаалтан
А. Хяналт шалгалт			
1	Хүнсний түргэн гэмтэх, эмзэг бүтээгдэхүүн тээвэрлэгч иргэд, байгууллагуудад Улаанбаатар хотын хяналтын 4 цэгт, орон нутгийн хяналтын цэгүүд болон шугам замд шалгалт хийх	II, IV улиралд	ЗТХЯ, НМХГ, аймгийн МХГ, НТГ, "АТУТ" ТӨҮГ
Б. Байгууллага, иргэдэд зориулсан сургалт семинар, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэх ажил, тандалт судалгааг зохион байгуулах			
1	Авто үйлчилгээ эрхлэгч иргэн, аж, ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх (Улаанбаатар хотод 100, орон нутагт 100)	II-III улиралд	ЗТХЯ, НМХГ, аймгийн МХГ, НТГ, "АТУТ" ТӨҮГ
2	Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын автотээврийн хэрэгслийн ашиглалтын байдал, засвар үйлчилгээнд тандалт судалгаа хийх	I улиралд	ЗТХЯ, НМХГ, НТГ
3	Зам, тээврийн салбарын хяналтын улсын байцаагч нарт мэргэшил дээшлүүлэх нэгдсэн сургалт зохион байгуулах	II улиралд	ЗТХЯ, МХЕГ, НТГ, "АТУТ" ТӨҮГ, "УБТЗ" ХНН

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГОМБОСҮРЭН

УХА0382
5919487
1116126781

НИЙСЛЭЛИЙН ТЭЭВРИЙН
ГАЗРЫН ДАРГА



Д.ОТГОНБААТАР

1115108253 ± 2117428

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн
даргын 2018 оны 02 дугаар гэрээ
2018 29